



БАТЛАВ.
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

С.МӨНХНАСАН



БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨҮГ-ҮНЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

БАРИЛГЫН АЖИЛД ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 05 дугаар сарын 03-ний өдөр Дугаар 16/22 Улаанбаатар хот

Нэг талаас “Иргэний нисэхийн ерөнхий газар.” /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны дарга Б.Амартувшин, нөгөө талаас “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ /цаашид “Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч” гэх/, түүнийг төлөөлж Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга Э.Мөнхсүх нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид “гэрээ” гэх/ байгуулав.

Монгол Улсын “Барилгын тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”, 2018 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 316 дугаар тогтоол, 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 343 дугаар тогтоолоор батлагдсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам”-ын 1.5 дахь заалт болон бусад холбогдох дүрэм, журмуудыг үндэслэн барилгын ажилд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэхэд талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч нь Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дэвсгэрт баригдаж буй “Дэлүүн болдог нисэх буудал” төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлнэ. Гэрээний хавсралтад барилгын ажлын үе шатанд захиалагчийн техникийн хяналт тавих ажилтан, хэрэгжүүлэх хугацаа, зардлын тооцоог тусгав. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэгт байна.

1.2. Захиалагч нь 1.1 дэх хэсэгт заасан ажлыг Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчээр гүйцэтгүүлж, энэ гэрээнд заасан техникийн хяналтын зардлыг захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчид шилжүүлнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Энэхүү гэрээ нь 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуустал хүчин төгөлдөр байна.

Гурав. Техникийн хяналтын зардал

3.1. Талууд техникийн хяналтын зардлыг дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцсон болно.

3.2. Захиалагчийн техник хяналтын зардал **6 275 040** /зургаан сая хоёр зуун далан таван мянга дөч/ төгрөг байхаар тохиролцож, захиалагч гэрээний 3.1.2, 3.1.3-т заасан хуваарийн дагуу шилжүүлнэ.

3.2.1. Захиалагч гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор 50% болох **3 137 520** /гурван сая нэг зуун гучин долоон мянга таван зуун хорь/ төгрөгийг Барилгын хөгжлийн төвийн Худалдаа хөгжлийн банкны **2600078536** тоот дансанд шилжүүлнэ.

3.2.2. Захиалагч гэрээ дуусгавар болж, ажил хүлээлцэх акт үйлдсэнээс хойш 3 хоногийн дотор үлдсэн 50% болох **3 137 520** /гурван сая нэг зуун гучин долоон мянга таван зуун хорь/ төгрөгийг Барилгын хөгжлийн төвийн **2600078536**-ХХБанкны дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн өндөр түвшинд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг шаардах.

4.2. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

4.3. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн дотоод ажилд шууд оролцохгүйгээр ажлын явц, түүний чанар, үр дунд хяналт тавина.

4.4. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй.

Тав. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн эрх үүрэг

5.1. Энэхүү гэрээний 1.1 дэх хэсэгт заасан ажлыг 2.1 дэх хэсэгт заасан хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн чанартай гүйцэтгэнэ

5.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээ, тайланг захиалагчид гэрээний 2.1-д заасан хугацаанд тухай бүр гарган албан бичгээр хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл гарган өгөх.

5.3. Энэхүү гэрээний 3.1.1 дахь хэсэгт заасан төлбөр тооцоог захиалагчаас шаардаж авах.

5.4. Барилгын ажлын захиалагчийн техникийн хяналтын зардал болон бусад санхүүжилттэй холбогдолтой асуудлыг захиалагчид тавьж шийдвэрлүүлнэ.

5.5. Барилга угсралтын ажлын үе шатанд 1.1-д заасан хавсралтын дагуу тохиролцсон хугацаанд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж ажиллана.

5.6. Чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн зөрчил дутагдалтай барилгын ажлын талаар дүгнэлт гаргах, тогтоосон хугацаанд гүйцэтгэгчийн зардлаар засуулах, учирсан хохирлыг арилгуулах, шаардлага биелүүлээгүй тохиолдолд санхүүжилтийг зогсоох, гэрээний хариуцлагыг тооцох саналыг захиалагчид албан бичгээр хүргүүлнэ.

5.7. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч нь барилга байгууламжийн техникийн баримт бичгийн иж бүрдлийг шалгаж холбогдох тайлан мэдээг гаргаж өгнө.

5.8. Захиалагчийг мэргэжлийн зөвлөгөөгөөр хангаж ажиллана.

5.9. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн төрийн болон албаны нууцтай холбоотой асуудлыг чанд хадгалж, энэ талаарх холбогдох хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллана.

5.10. Захиалагчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /Тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллага гэрчилнэ.

Долоо. Маргаан шийдвэрлэх журам

7.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцо замаар шийдвэрлэнэ.

7.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шүүх байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.3. Захиалагч техникийн хяналтын зардлыг шилжүүлээгүй тохиолдолд буруутай тал харилцан 0.01%-ийн алданги төлнө.

Найм. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

8.1. Ажил гүйцэтгэх явцад ажлын нөхцөлд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Ес. Бусад заалт

9.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэв. Хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй болно.

9.2. Талуудын хамтын ажиллагааг хамтарсан журам боловсруулан хэрэгжүүлж ажиллах болно.

ГЭРЭЭГ ХЯНАСАН

Хууль эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга

П.АРИУНБОЛД

"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ЫН
Захиргаа, удирдлагын хэлтсийн
дарга


Г.ТУВШИНЖАРГАЛ

ГЭРЭЭТЭЙ ТАНИЛЦСАН

Санхүү, хөрөнгө
газрын дарга

оруулалтын


“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын
Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсийн
дарга


Д.ХАТАНБААТАР

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


Г.ГАНТУУЛ

Хөрөнгө оруулалт, захиалагчийн
албаны дарга


Б.АМАРТУВШИН

Хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
21 дүгээр хороо, Буянт-Ухаа
Утас: 7128-2064

Барилга
захиалагчийн хяналтын хэлтсийн
дарга


Э.МӨНХСҮХ

Хаяг:
Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
Их тойруу-1 “Барилгын хөгжлийн төв”
Утас: 326657, 88003688
Цахим хаяг: info@barilga.gov.mn
Харилцах банк: ХХБ банк
Дансны дугаар: 2600078535

Талуудын хооронд 2022 оны 4 дүгээр сарын
.....өдөр байгуулагдсандугаар гэрээний
хавсралт

TTA7990 6 5104751

Захиалагчийн техникийн хяналт гүйцэтгэх ажилтнуудын нэрс

№	Овог, нэр	Албан тушаал	Мэргэжил	Утасны дугаар
1	Э.Мөнхсүх	Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга	Барилгын инженер	99096050
2	С.Сүхтуяа	Бүс хариуцсан ахлах инженер	Барилгын инженер	99079559
3	Г.Батбаяр	Хяналтын инженер	Цахилгаан системийн инженер	88078141
4	Ж.Хадбаатар	Хяналтын инженер	Халаалт, агаар сэлгэлтийн инженер	91927949

Барилгын ажлын үе шатанд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх хугацаа болон зардлын тооцоо

№	Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх			Захиалагчийн техникийн хяналтын зардал			Дүн
	Хугацаа	Хүний тоо	Өдөр	Цалин	Замын зардал	Томилолт	
1	2022.04.10	4	4	900,000	391,680	800,000	2,091,680
2	Тухайн үед шийдэх	4	4	900,000	391,680	800,000	2,091,680
3	2022.07.20	4	4	900,000	391,680	800,000	2,091,680
Нийт							6,275,040

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Төвч утга	Гэрээ байгуулах тухай
Тайлбар	<p>“Дэлүүн болдог нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум-/ын ажил”-ыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийн дагуу ИНЕГ-аас Барилгын хөгжлийн төвд 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/458 албан тоотоор мэргэжлийн байгууллагын зүгээс арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийг тавьсан.</p> <p>Тус төвөөс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 1/671 тоот албан бичгээр хамтран ажиллахаар уламжлан мэдэгдсэний дагуу хамтран ажиллахаар болж уг гэрээг байгуулж байна.</p> <p>Санхүүжилтийг “Биг Монголиа Билдинг” ХХК-ийн Захиалагчийн хяналтын зардлаас 6,275,040.00 төгрөгөөр санхүүжнэ.</p>
Хэлтэс, тасгийн нэр	Худалдан авах ажиллагааны тасаг
Огноо	2022 он 04 сар 07 өдөр

Хянасан:

ХОЗА-ны дарга:

Б.Амартувшин

Боловсруулсан:

ХОЗА-ны мэргэжилтэн:

Г.Хишигдэлгэр

ГЭРЭЭНИЙ ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ

Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>① №-ын бүрэлдэхийн дэхь олон улсын төсөлд өгсөн саналыг түүхийн дэхь олон улсын төсөлд өгсөн саналыг түүхийн дэхь олон улсын төсөлд өгсөн саналыг</p>	
<p>② иштэвчийн замын төслийн хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг түүхийн дэхь замын төслийн хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг</p>	
Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>Мурзин Г. - он цэвэртэй дэхь олон улсын төсөлд өгсөн саналыг</p>	
<p>③ Баян Монголын эмчилгээнд ХХК-ийн төсөлд өгсөн саналыг түүхийн дэхь эмчилгээнд ХХК-ийн төсөлд өгсөн саналыг</p>	
Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>④ Гарынжар Чингисханын төсөлд өгсөн саналыг иштэвчийн замын төслийн хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг</p>	
<p>⑤ М.Д. Батбаярын төсөлд өгсөн саналыг иштэвчийн замын төслийн хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг</p>	
Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>Ачинаа иштэвчийн замын төслийн хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг түүхийн дэхь замын төслийн хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг</p>	
<p>II чиглэл:</p>	
<p>① Говь-Алтайн 3ХЗ-ийн төсөлд өгсөн замын</p>	
Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>Жамшид Охижадов (Говь-Алтай)</p>	
<p>① 3ХЗ-ийн төсөлд өгсөн замын 62% тийн баар түүхийн дэхь олон улсын төсөлд өгсөн саналыг</p>	
Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>.....</p>	
<p>.....</p>	
<p>.....</p>	
<p>.....</p>	
Албан тушаалтны нэр:	Огноо:
<p>.....</p>	